



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, хүчингүй болгох тухай

Монгол улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5. дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ - Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.


3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Асгат сервис ХХК-ийн “Лион тауэр” зочид буудлын 17/021, Улаанцарам ХХК-ийн “МЖ” дэн буудлын 16/107, Гинза ХХК-ийн “Нью ворлд” дэн буудлын 17/040 гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.


ДАРГА



Д.БАТСҮХ

1150500057

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018-оны 13 сарын 13
өдрийн 10 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2018.03.13

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Асгат сервис ХХК	2077612	Лион тауэр	БЗД-ийн 8-р хороо Энхтайвны өргөн чөлөө 21

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 03 сарын 13
өдрийн А.19 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.03.13

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Улаанцарам ХХК	2564246	МЖ	ХУД-ийн 10-р хороо Буянт ухаа хороолол 64/1
2	Гинза ХХК	2341832	Нью ворлд	БЗД-ийн 1-р хороо 47
3	Кристалл клейр ХХК	5375762	Рүүмс	СБД-ийн 6-р хороо Их сургуулийн гудамж 40
4	Чандагатайн тээвэр ХХК	6267602	Ди эс	СБД-ийн 6-р хороо Их сургуулийн гудамж 9-4

--ooOoo--